

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(Хяналт шалгалтын газар)

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Суурь түвшин, үр дүнгийн үзүүлэлт (2020 он)	Хүрсэн түвшин, үр дүн	Хувь	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ						
Зорилт 9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.						
1.	9.2.33. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.	2021-2030	-	1.Хот байгуулалт, хотын стандартын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу сургууль, цэцэрлэг, эмнэлгийн-7, нийтийн зориулалттай орон сууцны-11 нийт 18 барилгад Барилгын тухай хууль болон “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.21-ийн холбогдох шаардлагуудыг хангаагүй, болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтыг хориглох тухай Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг Хот байгуулалт, хотын стандартын газарт хүргүүлсэн. 2.Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Эдү апартмент хотхоны 207 дугаар байр, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо Хонхор 16 айлын орон сууцны барилгуудад хяналт шалгалт хийж, Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, БНБД 22.01.21-ийн холбогдох шаардлагуудыг хангахгүй, болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй болсон талаарх Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн дүгнэлт болон холбогдох материалыг Хяналт шалгалтын газрын	100%	ХБХСГ, ХШГ, НОБГ

1	2	3	4	5	6	7
				даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 05 дугаар хурлаар хэлэлцүүлж, ашиглалтыг хориглохоор шийдвэрлэсэн. Шийдвэрийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/845 дугаартай албан бичгээр Нийслэлийн Орон сууцны бодлогын газар, Хот байгуулалт, хотын стандартын газар, Нийслэлийн Орон сууцны корпораци, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлсэн.		

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.МӨНХБАЯР

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.МӨНХТУЯА

НЭГТГЭСЭН:

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ГАЧМАА

